

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ДОЛООШАР ЗАГ ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2023/25-НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn
Өмнөговь аймаг
2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас:99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас:80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Азуре хүлүг аудит ХХК
Утас:70110090 Цахим хаяг: audit@azure.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.15 № 216

танай _____ -ны № _____ -г

Г БАЯН-ОВОО СУМЫН "ДОЛОО
ШАР ЗАГ" ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Д.СОНИНБАЯР
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баян-Овоо сумын Долоо шар заг ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баян-Овоо сумын Долоо шар заг ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"-д заасантай нийцээгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Төлбөрийн баримтаар баталгаажаагүй 8.9 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Өмнөговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 7/20 тоот тогтоолоор 13.3 сая төгрөгийн сэлбэг худалдсан байна.

• 016020287

Аудитын гол асуудал

Долоошар заг ОНӨААТҮГ-ын 2022 оны нийт орлогыг 384.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 427.1 сая төгрөгөөр, 43.1 сая төгрөгийн алдагдалтай байхаар эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Гүйцэтгэлээр 383.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 424.6 сая төгрөгийн зардал гарган, 41.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй бусад асуудал байхгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
2	Эргэлтийн хөрөнгө		
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6,456,249.55	2,799,977.80
4	Дансны авлага	12,276,069.62	5,755,073.26
5	Татвар НДШ-ийн авлага	-	-
6	Бараа материал	8,664,894.28	8,313,648.64
7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		57,654.75
8	Эргэлтийн хөрөнгийн дүн	27,397,213.45	16,926,354.45
9	Эргэлтийн бус хөрөнгө		
10	Үндсэн хөрөнгө	2,597,305,511.86	2,503,898,952.89
11	Бусад үндсэн хөрөнгө	-	-
12	Дуусаагүй барилга	-	-
13	Биет бус хөрөнгө	9,898,750.14	10,761,250.18
14	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,607,204,262.00	2,514,660,203.07
15	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,634,601,475.45	2,531,586,557.52
16	ӨР ТӨЛБӨР		
17	Богино хугацаат өр төлбөр		
18	Дансны өглөг	-	-
19	Цалингийн өглөг	-	-
20	Орлогын татварын өглөг	-	-
21	ХАОАТ-ын өглөг	-	-
22	НӨАТ-ын өглөг	-	8,397,623.23
23	Бусад өглөг	-	12,138,284.76
24	Урьдчилж орсон орлого	30,360.00	303,057.00
25	Богино хугацаат өр төлбөрийн дүн	30,360.00	20,838,964.99
26	Урт хугацаат өр төлбөр		
27	Бусад урт хугацаат өглөг	2,407,380,403.54	2,324,707,272.74
28	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,407,380,403.54	2,324,707,272.74
29	Өр төлбөрийн нийт дүн	2,407,410,763.54	2,345,546,237.73
30	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
31	Өмч : а) төрийн	414,198,358.33	414,198,358.33
32	б) хувийн	-	-
33	б) хувьцаат	-	-
37	Дахин үнэлгээний нөөц	19,082,920.20	19,082,920.20
38	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	78,063,775.00	78,063,775.00
39	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(284,154,730.62)	(325,304,733.74)
40	Эзэмшигчдийн өмчийн дүн	227,190,322.91	186,040,319.79
42	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	2,634,601,086.45	2,531,586,557.52

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого /цэвэр/	297,932,859.00	301,764,274.58
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	246,393,254.68	279,782,708.78
3	Нийт ашиг (алдагдал)	51,539,604.32	21,981,565.80
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	92,928,396.72	81,705,175.80
9	Борлуулалт маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	150,637,185.45	144,836,744.72

11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	(11,422,149.21)	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(17,591,333.62)	(41,150,003.12)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(17,591,333.62)	(41,150,003.12)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(17,591,333.62)	(41,150,003.12)
27	Орлогын нийт дүн	-	-
28	Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	492,262,133.33	19,082,920.20	(266,563,397.00)	244,781,656.53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	492,262,133.33	19,082,920.20	(266,563,397.00)	244,781,656.53
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(17,591,333.62)	(17,591,333.62)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	492,262,133.33	19,082,920.20	(284,154,730.62)	227,190,322.91
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	492,262,133.33	19,082,920.20	(284,154,730.62)	227,190,322.91
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(41,150,003.12)	(41,150,003.12)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	492,262,133.33	19,082,920.20	(325,304,733.74)	186,040,319.79

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2	Мөнгөн орлогын дүн	275,964,931.62	350,783,390.71
3	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	275,964,931.62	350,783,390.71
4	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
5	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
6	Буцаан авсан албан татвар	-	-
9	Мөнгөн зарлагын дүн	276,737,309.15	345,111,364.83
10	Ажилчдад төлсөн	83,941,670.00	101,301,433.00
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	30,275,761.75	35,408,358.03
12	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	84,404,655.00	111,058,294.00
13	Ашиглалтын зардалд төлсөн	22,107,692.46	31,263,856.46
14	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	12,202,171.00	26,452,475.00
16	Татварын байгууллагад төлсөн	34,286,850.94	36,036,702.34
18	Бусад мөнгөн зарлага	9,518,508.00	3,590,246.00
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(772,377.53)	5,672,025.88

20	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
21	Мөнгөн орлогын дүн	-	-
22	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
23	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
24	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
29	Мөнгөн зарлагын дүн	-	-
30	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
35	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
36	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
37	Мөнгөн орлогын дүн	-	-
38	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
39	Хувьцаа болон өмчийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
40	Валютын ханшийн зөрүү	-	-
41	Мөнгөн зарлагын дүн	-	-
42	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
43	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн мөнгө	-	-
46	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
47	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(772,377.53)	5,672,025.88
48	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,556,601.20	784,223.67
49	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	784,223.67	6,456,249.55

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Тайлант оны (2022)			
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Дулааны мөнгөн орлого	301,015,794.00	301,764,274.58	748,480.58	100.25
2	Бусад орлого	83,023,050.00	81,705,175.88	(1,317,874.12)	98.41
3	Нийт орлого	384,038,844	383,469,450.46	(569,393.54)	99.85
1	Цалин	136,903,964.00	136,731,686.00	(172,278.00)	99.87
2	НД-ийн шимтгэл	21,558,075.00	21,793,794.04	235,719.04	101.09
3	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	93,480,883.00	93,543,665.93	62,782.93	100.07
5	Шатахуун авахад	19,000,000.00	21,129,336.02	2,129,336.02	111.21
6	Тээврийн хөлс	58,925,000.00	57,428,275.95	(1,496,724.05)	97.46
7	Хөдөлмөр хамгаалал	21,000,000.00	20,428,995.56	(571,004.44)	97.28
8	Албан томилолт	750,000.00	726,000.00	(24,000.00)	96.80
9	Сургалтын зардал	160,000.00	-	(160,000.00)	-
10	Цахилгааны зардал	25,600,000.00	25,575,209.88	(24,790.12)	99.90
11	Шуудан холбооны	900,000.00	804,543.00	(95,457.00)	89.39
12	Бичиг хэргийн зардал	1,200,000.00	1,113,924.00	(86,076.00)	92.83
13	Уурын зуухны сэлбэг засвар үйлчилгээ	14,700,000.00	14,690,352.00	(9,648.00)	99.93
14	Автомашинны засвар үйлчилгээ	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
16	Бусад	6,000,000.00	4,194,705.32	(1,805,294.68)	69.91
17	Ажлын хөлс	2,750,000.00	2,716,666.00	(33,334.00)	98.79
18	Хот тохижилтын зардал	105,000.00	60,000.00	(45,000.00)	57.14
20	Тэтгэмж	1,921,255.00	1,770,083.00	(151,172.00)	92.13
21	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,536,500.00	2,479,206.80	(57,293.20)	97.74
22	Акталсан барилга буулгах зардал	16,060,000.00	15,911,009.00	(148,991.00)	99.07
24	Усны төлбөр	1,600,000.00	1,522,001.00	(77,999.00)	95.13
	Зарлагын дүн	427,150,677	424,619,454	(2,531,223.50)	99.41
1	Татварын өмнөх ашиг	(43,111,833)	(41,150,003.04)	1,961,829.96	95.45
2	Орлогын татвар	-	-	-	-
3	Цэвэр ашиг	(43,111,833)	(41,150,003)	1,961,829.96	95.45

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 3 зөрчил¹ илэрснээс төрийн хэмнэлтийн тухай хууль, хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах болон шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ажиллах 3 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Ажилтны илүү цагийн хөлс олгохдоо илүү цагийн нормыг хууль, журамд зааснаас хэтрүүлэн олгосон байна.	1	2,579.3	-	-	1	2,579.3	-	-
	Дүн	1	2,579.3	-	-	1	2,579.3	-	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Байгууллагын хөрөнгөөр ажилчдыг сувилалд амраасан байна.	1	5,220.0	-	-	1	5,220.0	-	-
	Дүн	1	5,220.0	-	-	1	5,220.0	-	-
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-	-	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	-	-	1	-
	Нийт дүн	3	7,799.3	-	-	2	7,799.3	1	-

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.